

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН БЭГЗЖАВ ОВОГТОЙ ЯНЖМААГИЙН 2025 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь		
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)					
			3	4	5	6				
			1	2						

1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох

1.	Арга хэмжээ 2.1.  Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад болон, дагалдан нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд хамтран ажиллах  /AX-2050 - 2.3.3, ЗГУАХ 2024-2028 -2.1.1.23/	Хуулийн төсөл /тоо/	0	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад хамтран ажиллах хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаар болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын чиглэлээр тусгах заалтуудыг боловсруулахад хамтран ажиллаж байна.	01-06	70
		Дагалдан гарах хуулийн төсөл /тоо/	0	20		01-06	
		Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/ Хуулийн төсөл /тоо/	0	1		01-06	

2. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ								
Зорилт 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил бодлогын удирдамжаар хангах								
	Арга хэмжээ 4.1.  Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний зураглалын төслийг хамтран боловсруулахад ажиллах	Зураглалын тоо	0	0	Xүүхдийг эхийн хэвлэйд бүрэлдэхээс эхлээд хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, үнэлэх, нийгмийн оролцоог хангахад чиглэсэн тогтолцоог оновчтой бүрдүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгаж, амьдралын туршид нь төрийн үйлчилгээг хүртээмжтэй, хэрэгцээнд нь нийцсэн байдлаар хүргэх нийгмийн үйлчилгээний зураглалыг Энэрлийн түүчээ, Аутизмд хийсэн аялал, Ээлтэй ертөнц төрийн бус байгууллагын төлөөллүүдтэй хамтран боловсрууллаа.  Зураглалын эхний хувилбарыг 5 сарын 22-ны өдөр Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны холбогдох албан хаагчдад танилцуулан саналыг тусгав.  Мөн 5 сарын 26-ны өдөр Төрийн бус байгууллагуудын төлөөллүүдэд танилцуулан санал авах уулзалтыг зохион байгуулав.		01-06	90
2.	Дэд арга хэмжээ 4.1.1  Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалалын үйлчилгээний ерөнхий зураглал боловсруулахад 0-18 наасны хүүхдэд боловсрол эзэмшүүлэх чиглэлээр тусгах санал боловсруулах	Боловсруулсан санал	0	0	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний зураглалыг хэрэгжүүлэн үр дүнтэй ажиллахад бодлогын түвшинд тусгах асуудлуудыг нэгтгэн 3 сайдын уулзалтанд танилцуулахаар бэлтгэн ажиллаж байна. Үүнд:  Боловсролын асуудлаар: <ul style="list-style-type: none"><li>Амьдралд бэлтгэх хөтөлбөрийг боловсролын үйлчилгээнд тусган хэрэгжүүлэх</li><li>Сургалтын хөтөлбөрийн тохируулгыг боловсролын түвшин бүрт хийж, тогтмол хугацаанд шинэчилдэг байх</li><li>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эрэлттэй ажил, мэргэжлийн жагсаалтыг гаргаж хүний нөөцийг бэлдэх</li></ul> 3 сайдын хамтран шийдэх асуудлаар: <ul style="list-style-type: none"><li>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалалын салбар комисстий хамтран ажиллах зөвлөн туслах,</li></ul>	01-06	90	

					зохицуулагч ТББ-уудыг туршилтаар ажиллуулах /Нийслэл+аймгийн сургууль цэцэрлэгийг сонгон ажиллах/ <ul style="list-style-type: none"> <li>Шилжилтийн хөтөлбөр"-ийн талаар холбогдох хуулинд тусган хэрэгжүүлэх</li> <li>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд эзэмшихэд дэмжлэг үзүүлэх дэмжих төвийн үйлчилгээ тогтворжуулах</li> <li>Амьдралд бэлтгэх хөтөлбөрийг хуулинд тусгаж хэрэгжүүлэх</li> </ul>		
3.	Арга хэмжээ 4.2. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг туршихад хамтран ажиллах /ЗГУАХ 2024-2028 -2.1.1.25/	Туршилт хийх аймаг, дүүрэг /too/	0	0	Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг нэвтрүүлэн туршихад хамтран ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үнэлгээ, хөгжлийн төлөвлөгөөг ICF-ын аргачлалаар хийхийг комиссын дүрмийн шинэчлэлд тусгах, комиссын гишүүдийг чадавхижуулах сургалтын хөтөлбөрт ICF-ын талаарх ойлголтыг тусган мэдээлэл арга зүйгээр хангах ажлуудыг хийж байна.	01-06	60
	Дэд арга хэмжээ 4.2.1 Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилалыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд нэвтрүүлэх санал боловсруулах	Туршилт хийх аймаг, дүүрэг /too/	-	-	Үйлдлийн чадвар алдалтын системээр /ICF/ хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, тогтоох олон улсын аргачлалыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд нэвтрүүлэх санал боловсруулах чиглэлээр 06 сарын 16-ны өдөр НҮБ-ын хүүхдийн сантай уулзах уулзалтын үеэр ярилцаж хамтран ажиллахаар болсон. Тус ажлын хүрээнд Эрүүл мэндийн яам, Боловсролын яам болон чиг үүргийн хувьд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	01-06	60
	Дэд арга хэмжээ 4.2.2 Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилалыг хөгжлийн	Боловсруулсан төсөл	-	1	Хугацаа болоогүй.		

	бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд нэвтрүүлэх аргачлалын төсөл боловсруулах						
4.	Арга хэмжээ 4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	Засгийн газрын тогтоолын төсөл /тоо/	-	-	Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм"-ийн төслийг шинэчлэн боловсруулж төрийн болон төрийн бус байгууллага, салбар комиссын гишүүдэд 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, дүрмийн төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн ажиллаж байна.	01-06	70
	Дэд арга хэмжээ 4.3.1 ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийн төслийг боловсруулж холбогдох төрийн болон ТББ, салбар комиссуудаас санал авах ажлыг зохион байгуулах	Дүрмийн төсөл	-	1	Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм" нь 9 бүлэг 107 заалтаас бүрдэж байсан бөгөөд <ul style="list-style-type: none"> <li>- комиссын шийдвэр гаргах үйл ажиллагаа;</li> <li>- төв, салбар комисс, дэд зөвлөлийн бүрэлдэхүүн;</li> <li>- тавигдах шаардлага, томилж, чөлөөлөх;</li> <li>- салбар комиссын бүрэлдэхүүнд ажиллах байгууллагын нийтлэг чиг үүргийн талаарх заалтуудыг тусган ирүүлсэн саналуудыг үндэслэн 11 бүлэг 136 заалт бүхий дүрмийн төслийг боловсруулсан.</li> </ul>	01-06	70
	Дэд арга хэмжээ 4.3.2. ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийн төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн, хэлэлцүүлэг зохион байгуулах	Хэлэлцүүлэг /тоо/	-	2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн төсөл танилцуулах хэлэлцүүлгийг Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, салбар комиссын гишүүд болон төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан 2 удаа зохион байгуулсан.	01-04	70
	Дэд арга хэмжээ 4.3.3	Санал /тоо/		-	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн төсөлл санал		

	ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийг төсөлд яамдуудаас санал авах ажлыг зохион байгуулах		-		авах ажлыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар ажиллаж байна.		
5.	Арга хэмжээ 4.4.  Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг төв, орон нутагт ажиллуулах чиглэлээр холбогдо шийдвэрийн төсөл боловсруулах	Үйл ажиллагаа явуулах төв /too/	4	7	<p>Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг төв, орон нутагт ажиллуулах чиглэлээр холбогдо шийдвэрийн төсөл боловсруулах</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвүүдийг сонгон шалгаруулаад арга зүйн дэмжлэг үзүүлэн хамtran ажилласан бөгөөд Баянхонгор аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Реха центер, Энэрэлийн түүчээ, Энх гэр бүл, Эрхэм нандин сувд, Аутимзд хийсэн аялал, Ээлтэй Ертөнц төрийн бус байгууллагуудын 7 дэмжих төв шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.</p>	01-06	100
	Дэд арга хэмжээ 4.4.1  Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрмийг Боловсролын яам, Эрүүл мэндийн яамтай хамtran боловсруулж, батлуулах	Дүрэм /too/	1	1	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28.1 дэхь заалт, Боловсролын тухай хуулийн 17.9 дэхь заалтуудын хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм”-ийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан төсөлд яам, агентлаг, газар хэлтсийн холбогдо албан хаагчдын саналыг нэгэтгэн манай яамны зүгээс хариуцан ажиллах чиглэлээр заалтуудыг боловсруулан, тусгаж ажилласан.</p> <p>Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 сарын 21-ний өдрийн A/85, A/55, A/49 хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм” баталсан.</p>	01-03	100

Дэд арга хамжээ 4.4.2 “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ төвд дэмжих үйлчилгээний удиридамж, жишиг үнэ, ашиглах хэрэглэгдэхүүний жагсаалт, удирдамжийн тесөл боловсруулж, батгуулах	Сайдын тушаал /тоо/	1	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол зэмшихэд дэмжтэг узүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн үйлчилгээний аргачлал заавар, үнэ тарифыг Эрхэм нандин сувд, Энэрийн түүчээ, Аугизмд хийсэн аялал, Ээлтэй ертөнц төрийн бус байгууллагын төвлөгүүдтэй хамтран боловсруулж Гэр бул хөдөлмер, нийтийн хамгааллын сайдын 2025 оны 03 сарын 10-ны өдрийн А64 тушаалаар баталсан. Тус аргачлал заварыг боловсруулахад шаардлагатай мэдээлээр хангах, ажлын багийн уулзалтыг зохион байгуулах, санал боловсруулан тусгаж ажилласан.	01-03	100
Дэд арга хамжээ 4.4.3. Үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулахад дэмжилгээ үзүүлж хамтран ажилласан.	Сонгон шалгаруулалт	-	5	Тус сонгон шалгаруулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар зохион байгуулан ажилласан. Сонгон шалгаруулалтын талаарх явцын мэдээ, Үр дүнгийн талаар тайлланг авч шаардлагатай мэдээ мэдээлэл арга зүйтээр ханган холбогдох Мэргэжилтүүдтэй хамтран ажилласан.		
Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвөөр Баянхонгор аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Река сентер, Хөгжлийн бэрхшээлтэй 25 хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвөөр Энээрэлийн түүчээ, Энх гэр бул, Хөгжлийн бэрхшээлтэй 40 хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвөөр Эрхэм нандин сувд, Аутимэд хийсэн аялал - Хөгжлийн бэрхшээлтэй 45 хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвөөр Ээлтэй-Ертөнц тус тус шалгарч гэрээ байгуулсан.	04-05	100				

	Дэд арга хэмжээ 4.4.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвийн үйл ажиллагааг орон нутагт байгуулах чиглэлээр ХБХЭМБНХ-ын салбар комиссыг арга зүйгээр хангах				ажиллагааг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан төвүүдийг орон нутгийн байршилаар авч үзвэл Баянзүрх дүүрэг, Хан-ул дүүрэг, Баянгол дүүрэг, Баянхонгор аймгуудад тус тус байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвийн үйл ажиллагааг орон нутагт хөгжүүлэх, чанартай үйлчилгээг бий болгох чиглэлээр шалгарсан байгууллагуудтай хамтарч ажиллах, бусад ижил үйлчилгээ үзүүлдэг төвүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлэн чадавхжуулах, дэмжих төвүүдийг сонгон шалгаруулах тендерийн талаарх мэдээллийг аймаг дүүргүүдийн салбар комиссоор дамжуулан хүргэх ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.		
--	--	--	--	--	---	--	--

Зорилт 7: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах

6.	Арга хэмжээ 7.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамtran зохион байгуулах,	Хэрэгжилтийн хувь	71	40	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулж байгаа арга хэмжээ, үйл ажиллагаанд тухай бүр хариуцсан чиглэлээр оролцон хамtran ажиллаж байна.	03-06	100
	Дэд арга хэмжээ 7.1.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмдэглэлт өдрийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд дэлхийн дауны өдрийт угтан мэдээлэл хүргэх постерийт бэлтгэн яамны цахим системд байршуулсан. Мөн Аутизмыг таниулах өдөрлөгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд төрөөс үзүүлж буй нийгмийн хамгааллын үйлчилгээ” сэдвээр илтгэл бэлтгэж танилцуулсан.	Хэрэгжилтийн хувь	-	50	2025 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмдэглэлт өдрийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд дэлхийн дауны өдрийт угтан мэдээлэл хүргэх постерийт бэлтгэн яамны цахим системд байршуулсан. Мөн Аутизмыг таниулах өдөрлөгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд төрөөс үзүүлж буй нийгмийн хамгааллын үйлчилгээ” сэдвээр илтгэл бэлтгэж танилцуулсан.	03-04	100

7.	Арга хэмжээ 7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамtran зохион байгуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	40	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нээлттэй өдөрлөг "Ability expo"-т бүсчлэн зохион байгуулах ажлын хүрээнд 2025 оны 05 сарын 14-ний өдрөөс 2025 оны 05 сарын 17-ны өдрүүдэд.govийн бүсийн арга хэмжээг Дундговь аймагт зохион байгуулсан. Тус арга хэмжээний зохион байгуулалтанд хамtran ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын бүсийн сургалтыг хариуцсан зохион байгуулах, комиссын хуралд оролцож арга зүйн дэмжлэг үзүүлэх, Ability expo-д оролцогчдын бүртгэл, зохион байгуулалтыг хариуцан ажилласан.	05	100	
АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТОД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:								
8.	Зорилт 1. "Хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг илрүүлэх, үнэлэх, тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн дэмжлэгт хамруулах төрийн бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх"	Арга хэмжээ 1.1. Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх наслын хөгжлийн хүүхдэд асаргааны тэтгэмжийг ялгаатай хүргэх ажлыг зохион байгуулах	Сайдын тушаалын /too/;	1	1	2025 оны улсын төсөвт хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд байнгын асаргааны мөнгөн тэтгэмжийг 30 хувиар нэмэгдүүлэн олгох чиглэлээр 6,8 тэрбум, памперсний хөнгөлөлт олгох чиглэлээр 1,8 тэрбум, дэмжих төвийн үйлчилгээг санхүүжүүлэх чиглэлээр 8,9 тэрбум төгрөг тус тус тусгагдсан. Үүний хүрээнд Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 28-ны өдрийн A/807, A/216 тоот хамтарсан тушаалаар баталсан Байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд 0-16 наслын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтээс хүнд хэлбэрийн өвчин гэмтлийг ялан тодорхойлох ажлыг зохион байгуулах ажлыг хэсэгт орж ажилласан. Эрүүл мэндийн сайд, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн A/68, A/62 тушаалаар жагсаалт, шалгуур үзүүлэлт батлагдсан.	01-05	100

					Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн 4.2.2 дахь хэсэгт зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн хүнд хэлбэрийг тодорхойлох ажлыг салбар комиссууд хариуцсан хийсэн. Салбар комиссуудад дээрх тушаалаар батлагдсан жагсаалт, шалгуур үзүүлэлтийг чиглэлийн хамт хүргүүлэн 2 удаагийн цахим хурлаар уулзалт, хурал зохион байгуулж арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн хамгийн олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй Сонгинохайрхан дүүргийн салбар комисс, төрөлжсөн мэргэжлийн багийнханд З дугаар сарын 25-нд сургалт зохион байгуулан үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажилласан.	
	Дэд арга хэмжээ 1.1.1. Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх наслын хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуурыг шинэчлэн боловсруулах,	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	100 %	Байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд 0-16 наслын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтээс хүнд хэлбэрийн өвчин гэмтлийг ялган тодорхойлох ажлын хэсгээс боловсруулсан жагсаалтын төсөлд ТББ, салбар комиссуудаас саналыг авч нэгтгэн боловсруулсан.	01-03 100
	Дэд арга хэмжээ 1.1.2. ХБХЭМБНХ-ын салбар комисс, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах	Хэлэлцуулыг /тоо/	-	2	Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийг эцсийн байдлаар хэлэлцүүлэн сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдээс гаргасан өргөдлийг судлан үзэж жагсаалтанд нэмэн боловсруулж батлуулсан.	01-03 100
	Дэд арга хэмжээ 1.1.3 Байнгын асаргааны тэтгэмж олгох ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, тоо мэдээллийг гаргаж танилцуулах	Хэрэгжилтийн хувь	-	80	2025 оны 5 дугаар сарын байдлаар байнгын асаргаатай, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмжийн 30 хувийн нэмэгдэлд 4668 хүүхэд буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 35 хувь нь хамрагдсан байна. Тус тоон мэдээллийг салбар комиссоос авч нэгтгэн боловсруулсан.	03-05 100
9.	Арга хэмжээ 1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд,	Сургалтанд хамрагдсан	0	7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхижуулах сургалтыг 2021 оноос хойш танхмын	05-06 100

	боловсрол, хамгааллын гишүүдийг бүсийн байгуулах	нийгмийн салбар комиссын чадавхжуулах сургалт зохион	салбар комиссын тоо			хэлбэрээр зохион байгуулаагүй бөгөөд шинэ мэдээ мэдээллийг албан бичгээр болон цахим уулзалтаар хүргэж ирсэн. Тиймээс гишүүдийг нэгдсэн байдлаар чадавхжуулах сургалтыг 2025 онд бүсчилсэн байдлаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2025 оны 05 сарын 16-ны өдөр.govийн бүсийн сургалтыг зохион байгуулж сургалтанд Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгийн 25 гишүүн хамрагдсан. Сургалтыг онол, практик хосолсон байдлаар зохион байгуулсан бөгөөд танхимиын сургалтын дараа Дундговь аймгийн салбар комиссын хуралд оролцож туршлага судалсан. Чадавхжуулах сургалт гишүүдэд маш хэрэгцээтэй байсан талаар сургалтын үеэр гишүүд хэлж байсан бөгөөд жил бүр сургалтыг зохион байгуулж байх талаар хүсэлт гаргаж байсан.		
10	Арга хэмжээ 1.3. Аймаг дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хуралд оролцож мэргэжил зүйн дэмжлэг үзүүлэх	Хуралд оролцсон салбар комиссын тоо	0	10	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг сайжруулах, хуралд оролцох , мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллах зорилгоор нийслэлийн Баянгол, Баянзүрх, Хан-уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн хуралд оролцсон. Нийслэлийн дүүргүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо их, 1 удаагийн хурлаар орох хүүхдүүдийн тоо 20-45 хүртэл байсан. Мөн тус хуралд оролцох үеэр байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн хүнд хэлбэрийг тодорхойлох ажлыг зохион байгуулж байсан тул ачаалал ихтэй ажиллаж байсан. Баянгол, Хан-уул, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн ЗДТГ-аас салбар комиссуудын үйл	01-06	90	

<p>ажиллагаа явуулах байрыг шийдэж өгсөн байна. Харин Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн хувьд хурлаа зохион байгуулах тогтмол өрөөгүй, дүүргийн эмнэлэгт тухайн өдөр сул байгаа өрөөнд хурлаа зохион байгуулдаг нь хүндрэлтэй байсан. Мөн хурлаар орох хүүхдийн тоо их байдаг учир 1 хүүхэдтэй ажиллах цаг бага, хөгжлийг дэмжих үйлчилгээнд төвлөрөхөөс илүү байнгын асаргааны сунгалтыг хийж гаргадаг алдаа дүүрэг бүрт байсныг тухай бүр анхааруулж зөвлөж ажилласан.</p> <p>2025 оны 01 сарын 10-нд Сэлэнгэ аймагт, 03 дугаар сарын 25-нд Хэнтий аймаг, 03 дугаар сарын 28-нд Сүхбаатар аймагт, 05 дугаар сарын 16-ны өдөр Дундговь аймагт тус тус ажиллаж салбар комиссын хурлуудад оролцсон.</p> <p>Орон нутгийн салбар комиссуудын хувьд хурал зохион байгуулах байр орон нутгаас шийдэж өгсөн, мөн хурлаар орох хүүхдийн тоо нийслэлээс харьцангуй бага буюу 10-15 хүүхэд орж байсан.</p> <p>Хүүхдийн хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах, кейс хэлэлцүүлэг хийх, нүүдлийн хурал зохион байгуулах ажлуудыг хангалтгүй хийж байгааг тухай бүр нь анхааруулж зөвлөн ажилласан.</p> <p>2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 6 дүүрэг, 4 аймгийн салбар комиссын хуралд оролцсон байна.</p>							
Зорилт 2.“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт шалгалт хийх”							
11.	Арга хэмжээ 2.1. Эрт үеийн хөгжил боловсролын протеж хөтөлбөрийн төслийг боловсруулж, батлуулах	Сайдын тушаалын /тоо/	0	-	Эрт үеийн хөгжил боловсролын протеж хөтөлбөрийн төслийг боловсруулж, зааврыг Боловролын яамтай хамтран батлуулахаар ажиллаж байна.	01-06	75
	Дэд арга хэмжээ 2.1.1 Эрт үеийн хөгжил боловсролын портеж хөтөлбөрийн төслийг төслийг боловсруулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	100 %	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, мэргэжлийн төрийн бус байгууллагатай хамтран хөтөлбөрийн төслийг төслийг боловсруулан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн зөвлөх М.Мөнхшүрт санал авахаар хүргүүлсэн.	01-04	50

	Дэд арга хэмжээ 2.1.2 Эрт үеийн хөгжил боловсролын портеж хөтөлбөрийн төслийг холбогдох яам, агентлагуудад танилцуулан хэлэлцүүлэх, санал авах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	40%	2025 оны 04 сарын 17-нд Боловсролын яамны холбогдох албан хаагчид болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн мэргэжилтнүүдийг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.	04	100
12.	Арга хэмжээ 2.2. Боловсролын яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтэстэй хамтран 2025-2026 оны хичээлийн жилд 2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	40%	2025 оны эхний хагас жилийн байдлаар цэцэрлэгийн насны 1630 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байгаагаас 1068 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байна. Үлдсэн 562 хүүхэд огт цэцэрлэгт хамрагдаагүй байна.	04-05	80
	Дэд арга хэмжээ 2.2.1. Аймаг дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоос цэцэрлэгийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг авч бэлтгэх	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	100 %	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаллын салбар комиссоос 2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгааг авч нэгтгэн Боловсролын яаманд хүргүүлсэн.	04-05	100
	Дэд арга хэмжээ 2.2.2. Судалгаанд үндэслэн ажлын төлөвлөгөө боловсруулж Боловсролын яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтэстэй хамтран ажиллах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	50%	Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч хөгжих нөхцөл байдлыг тодруулах, мэдээлэл солилцох, ойлголтоо нэгтгэх цахим сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Боловсролын яамнаас зохион байгуулсан бөгөөд тус сургалтанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар мэдээлэл танилцуулж оролцлоо.  Мөн тус сургалтанд 30 салбар комиссын боловсролын асуудал хариуцсан мэргэжилтнүүд бүрэн хамрагдаж мэдээлэл авсан.	05	90

Зорилт 3: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээллийн сан бий болгох, иргэдийг мэдээллээр хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах								
13.	Арга хэмжээ 3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын улирлын тайлангийн маягтыг шинэчлэн боловсруулах	Маягт /too/	5	4	Xөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын улирлын тайлангийн маягтыг шинэчлэн бэрхшээлтэй хүүхдийн тоон мэдээллийг шинэчлэн бэрхшээлийн төрлөөр болон хамрагдсан үйлчилгээгээр нь статистик мэдээг гаргадаг байхаар 4 маягт болгон өөрчлөн боловсруулж салбар комиссуудад 2025 оны 03 дугаар сард хүргүүлж 1 дүгээр улирлын тайланг туршилтын байдлаар шинэчилсэн маягтаар хүлээн авсан. Тайлангийн маягттай холбоотой салбар комиссын нарийн бичгүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн өөрчлөн боловсруулж Төв комиссын даргаар батлуулахаар ажиллаж байна.	01-03	80	
14.	Арга хэмжээ 3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд ажиллагаанд ашиглах мэдээллийн санг ашиглалтанд оруулах ажлыг Цахимжилт их өгөгдлийн бодлогын газартай хамтран зохион байгуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	50%	20%	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг <a href="http://WWW.CWD.MLSP.GOV.MN">WWW.CWD.MLSP.GOV.MN</a> Домэйн нэрээр териийн мэдээлэл солилцооны "ХҮР" болон E-Mongolia системтэй холбож, дүүргүүдийн салбар комиссын нарийн бичиг нарт нэвтрэх эрх үүсгэн салбар комиссын ээлжит хуралд туршин ашиглаж эхэлсэн. Одоогийн байдлаар мэдээллийн санг бүрэн ашиглахад хүүхдийн мэдээлэл дуудаж байгаа хурд муу байгаа учир сайжруулах шаардлагатай байгаа. Мэдээллийн санг ашиглахад үүсээд байгаа асуудлаар тус мэдээллийн санг хийж Жайка старт 2 төсөлд хүлээлгэн өгсөн компани захирал Б.Баярбаатар, Цахимжилт, их өгөгдлийн газрын дарга Н.Мөнхсанчир, Цахимжилт, их өгөгдлийн газрын салбарын цахимжилт хариуцсан ахлах шинжээч Ц.Сүхбаатар нарт танилцуулсан. Цаашид тус газартай хамтран мэдээллийн санг ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.	01-06	80	

Зорилт 4. "Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд"

15.	Арга хэмжээ 4.1. Японы хүүхдийг ивээх сантай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд “Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийг хэрэгжүүлэхдэд хамтран ажиллах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	100 %	50%	<p>Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийг хөгжлийг дэмжих нь” төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсэг буюу “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын гишүүдийг чадавхижуулах” зорилгоор 2024 оны 4 дүгээр сараас эхлэн тус төсөлтэй хамтран ажиллалаа. Ингэснээр 5 удаагийн зөвлөлдөх уулзалт, зорилтот 3 дүүрэг 2 аймгийн салбар комиссын гишүүдийг чадавхижуулах уулзалт, сургалтын ажлуудыг хамтран зохион байгууллаа. Мөн 2024 онд хэвлэн гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхижуулах сургалтын гарын авлагад шинээр батлагдсан дэмжих төвийн дүрэм, байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох өвчин гэмтлийн жагсаалтыг шинээр нэмж оруулах, техникийн болон агуулгын алдаатай мэдээллүүдийг засаж хэвлүүлэх саналыг хүргүүлснээр төслийн зөвлөх баг гарын авлагыг шинэчлэн боловсруулах ажлыг хийж байна.</p> <p>2025 оны 01 сард төслийн оролцогч аймаг болон Сэлэнгэ аймгийн салбар комиссын нүүдлийн хурлыг Сэлэнгэ аймгийн Мандал сум, Баруун хараа сумуудад зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэн оролцлоо.</p> <p>Мөн 2025 оны 01 сарын 24-ны өдөр төслийн нэгж болон Сонгинохайрхан дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хамтран зохион байгуулсан дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын сургалтанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Салбар комиссын эрх үүрэг, үйл ажиллагаа</li> <li>- Төрөлжсөн нарийн мэргэжлийн багийн үүрэг, үйл ажиллагаа</li> <li>- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт сэдвүүдээр сургалт бэлтгэн</li> </ul>	01-06	100

						орлоо. Сургалтанд нийт 67 эмч, албан хаагч хамрагдсан. Мөн төслийн зорилтот 5 аймаг дүүргийн салбар комиссуудад хурлын үеэр иргэдэд мэдээлэл өгөх үзүүлэн самбарыг хэвлэж өгөх ажилд эх бэлтгэлийг хянаж ажилласан. 2025-2027 онд хамтран ажиллах санамж бичгийг баталгаажуулан хүргүүлсэн.	
Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд							
16.	Арга хэмжээ 5.1. Авилгын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг тус тус хэрэгжүүлж, ажиллах;	Хэрэгжилтийн хувь	100 %	100 %	Авилгын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.	01-06	100%
17.	Арга хэмжээ 5.2. Хариуцсан асуудлын чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах ажлыг тухай бүр хийж холбогдох хурал, уулзалт, сургалтанд хамрагдан ажиллаж байна.	Бодлогын үндэслэлтэй санал өгсөн байна.	100 %	100 %	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах ажлыг тухай бүр хийж холбогдох хурал, уулзалт, сургалтанд хамрагдан ажиллаж байна.	01-06	100%
18.	Арга хэмжээ 5.3. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэх;	Шийдвэрлэлтийн хувь	100 %	100 %	2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 27 албан бичиг хуваарьлагдсан байна. Үнээс 12 албан бичиг хариутай байсан ба 11 албан бичгийг шийдвэрлэсэн, 1 албан бичиг хяналтанд байгаа бөгөөд шийдвэрлэлтийн хувь 91,67 байна. Хариугүй 15 албан бичиг хүлээн авсан бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаанд тусган ажиллаж байна. Мөн 5 өргөдөл гомдол хүлээн авч хариуг бүрэн хүргүүлж ажилласан. 2024 оны 04 дүгээр сарын 01 өдөр эрхэм нандин сувд тббаас ирүүлсэн "эрхэм нандин сувд" төрийн бус байгууллагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхчүүдээс ирүүлсэн 7 бүлэг 34 ажлын шаардлагын хүрээнд төлөвлөгөө гарган ажиллаж дараах	01-06	100%

						ажлуудыг хийж гүйцэтгэн 2025 оны 03 сарын 14 өдөр тус төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзалт хийж шаардлагын хариуг хургуулэх ажлыг зохион байгуулж холбогдох газар хэлтсээс хэрэгжилтийн тайланг нэгтгэн танилцуулсан. Үүнд:		
19.	Арга хэмжээ 5.4. Тайлан мэдээний батлагдсан хуваарийн дагуу хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичиг болон өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, бусад мэдээ, судалгааг нэгтгэн тайлгаха;	Хугацаанд нь тайлгнасан байна.	100 %	100 %	<ul style="list-style-type: none"> <li>- Байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хүнд хэлбэрийг тодорхойлж асаргааны тэтгэмийг 30 хувийн нэмэгдэлтэй олгож эхлэсэн;</li> <li>- Байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд памперсны хөнгөлөлт олгохоор шийдвэрлэсэн;</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чиглэлээр холбогдо заалтуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан;</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх хөнгөлөлт, тусламж, протез ортопедийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан зэрэг асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэхэд хамтран ажиллаж байна.</li> </ul>	01-06	100%	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Сурье түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /Биелэлт/			Эхлэх, дуусах хугацаа
1	2	3	4	5	6	7		

20	Арга хэмжээ 2.1. Салбарын холбогдох хууль эрх зүй, дүрэм, журмыг судлах, судалгааны баримт материалтай танилцах;	Арга хэмжээн ийгүйцэтгэлийн хувь	-	100%	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох дүрэм журмуудыг уншин судлаж өдөр тутмын үйл ажиллагаандaa ашиглан ажиллаж байна.	01-06	100%
21	Арга хэмжээ 2.2. Мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр зохиц сургалтад хамрагдах, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох;	Арга хэмжээн ийгүйцэтгэлийн хувь	-	100%	<p>Мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр яамнаас зохион байгуулж буй бүх сургалтанд бүрэн хамрагдсан бөгөөд баасан гараг бүр зохион байгуулдаг мэдээллийн цагаар дараах сургалтуудад хамрагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Оффисын ажлын байран дав эргономикийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь</li> <li>- Эртэч монгол хөтөлбөрийн сургагч багш Б.Төмөрочир Харилцааны 5 зарчим</li> <li>- Архив албан хэрэг хөтлөлтийн сургалт</li> <li>- Хөгжлийн бэрхшээл ба конвенц сургалт</li> <li>- "Албан бичгийн боловсруулалт, анхаарах асуудлууд" сургалт</li> <li>- "Soft skill ба бидний ажлын үр дүн" сургалт</li> <li>- "Байгууллагын стресс менежмент, хувь хүний мотивацижуулалт" сургалт</li> <li>- "Хүүхдийг хүмүүжүүлэх боломжгүй – харин эцэг эхчүүд насанд хүрнэ л гэж байдаг" сургалт</li> <li>- "Хиймэл оюун ухаан- хөдөлмөрийн шилжилт" сургалт</li> <li>- "Rhetoric буюу илтгэх урлаг" сургалт</li> <li>- Цагийн менежмент сургалт</li> </ul>	01-06	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГЭР БУЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ  
ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

( Албан тушаал )

Б.ЯНЖМАА

..... / ..... , 2028. 06. 13.  
( Нэр, гарын үсэг )( Огноо )

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
8 дугаар хаасралт

ГЭР БУЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН БЭГЗЖАВ ОВОГТОЙ ЯНЖМААГИЙН  
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,  
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Гэр бүлийн бодлогын газрын  
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, д ахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах эрх  
зүйн орчинг боловсронгуй болгох

1.	Арга хэмжээ 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад болон, дагалдан нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд хамтран ажиллах /AX-2050 - 2.3.3, ЗГУАХ 2024-2028 - 2.1.1.23/	42	7	49	49
----	---	----	---	----	----

ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил бодлогын удирдамжаар хангах

2.	Арга хэмжээ 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээний ерөнхий зураглал боловсруулахад 0-18 насны хүүхдэд боловсрол эзэмшүүлэх чиглэлээр тусгах санал боловсруулах	42	10	52	52
3.	Арга хэмжээ 4.2. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг туршихад хамтран ажиллах /ЗГУАХ 2024-2028 - 2.1.1.25/	42	7	49	49

	Дэд арга хэмжээ 4.2.1 Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилалыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд нэвтрүүлэх санал боловсруулах	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 4.2.2 Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилалыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд нэвтрүүлэх аргачлалын төсөл боловсруулах	42	7	49	49
4.	Арга хэмжээ 4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 4.3.1 ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийн төслийг боловсруулж холбогдох төрийн болон ТББ, салбар комиссуудаас санал авах ажлыг зохион байгуулах	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 4.3.2. ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийн төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн, хэлэлцүүлэг зохион байгуулах	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 4.3.3 ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийг төсөлд яамдуудаас санал авах ажлыг зохион байгуулах				-
5.	Арга хэмжээ 4.4. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг төв, орон нутагт ажиллуулах чиглэлээр холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах	60	10	70	70
	Дэд арга хэмжээ 4.4.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрмийг Боловсролын яам, Эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулж, батлуулах	60	10	70	70
	Дэд арга хэмжээ 4.4.2 “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвд үзүүлэх үйлчилгээний удирдамж, жишиг үнэ, ашиглах хэрэглэгдэхүүний жагсаалт, удирдамжийн төсөл боловсруулж, батлуулах	60	10	70	70
	Дэд арга хэмжээ 4.4.3. Үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	60	10	70	70

	Дэд арга хэмжээ 4.4.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвийн үйл ажиллагааг орон нутагт байгуулах чиглэлээр ХБХЭМБНХ-ын салбар комиссыг арга зүйгээр хангах	60	10	70	70
6.	Арга хэмжээ 7.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах,	60	10	70	70
	Дэд арга хэмжээ 7.1.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмдэглэлт өдрийн арга хэмжээг зохион байгуулах;	60	10	70	70
7.	Арга хэмжээ 7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах	60	10	70	70
АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТОД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:					
Зорилт 1. "Хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг илрүүлэх, үнэлэх, тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн дэмжлэгт хамруулах төрийн бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх"					
8.	Арга хэмжээ 1.1. Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн хүүхдэд асаргааны тэтгэмжийг ялгаатай хүргэх ажлыг зохион байгуулах	60	10	70	70
	Дэд арга хэмжээ 1.1.1. Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуурыг шинэчлэн боловсруулах,	60	10	70	70
	Дэд арга хэмжээ 1.1.2. ХБХЭМБНХ-ын салбар комисс, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах	60	10	70	70
9.	Дэд арга хэмжээ 1.1.3 Байнгын асаргааны тэтгэмж олгох ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, тоо мэдээллийг гаргаж танилцуулах	60	10	70	70
	Арга хэмжээ 1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхижуулах бусийн сургалт зохион байгуулах	60	10	70	70

10.	Арга хэмжээ 1.3. Аймаг дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хуралд оролцож мэргэжил зүйн дэмжлэг үзүүлэх	42	10	52	52
Зорилт 2."Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт шалгалт хийх"					
11.	Арга хэмжээ 2.1. Эрт үеийн хөгжил боловсролын протеж хөтөлбөрийн төслийг боловсруулж, батлуулах	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 2.1.1 Эрт үеийн хөгжил боловсролын портеж хөтөлбөрийн төслийг төслийг боловсруулах	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 2.1.2 Эрт үеийн хөгжил боловсролын портеж хөтөлбөрийн төслийг холбогдох яам, агентлагуудад танилцуулан хэлэлцүүлэх, санал авах	42	7	49	49
12.	Арга хэмжээ 2.2. Боловсролын яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтэстэй хамтран 2025-2026 оны хичээлийн жилд 2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	60	10	70	70
	Дэд арга хэмжээ 2.2.1. Аймаг дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоос цэцэрлэгийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг авч бэлтгэх	60	10	70	70
	Дэд арга хэмжээ 2.2.2. Судалгаанд үндэслэн ажлын төлөвлөгөө боловсруулж Боловсролын яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтэстэй хамтран ажиллах	60	10	70	70
Зорилт 3: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээллийн сан бий болгох, иргэдийг мэдээллээр хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах					
13.	Арга хэмжээ 3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын улирлын тайлангийн маягтыг шинэчлэн боловсруулах	42	7	49	49
14.	Арга хэмжээ 3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд ажиллагаанд ашиглах мэдээллийн санг ашиглалтанд оруулах ажлыг Цахимжилт их өгөгдлийн бодлогын газартай хамтран зохион байгуулах	42	7	49	49

Зорилт 4. "Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд"						
15.	Арга хэмжээ 4.1. Японы хүүхдийг ивээх сантай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд "Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах	60	10	70	70	
16.	Арга хэмжээ 5.1. Авилгын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг тус тус хэрэгжүүлж, ажиллах;	60	10	70	70	
17.	Арга хэмжээ 5.2. Хариуцсан асуудлын чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлгаха	60	10	70	70	
18.	Арга хэмжээ 5.3. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хургуулэх;	60	10	70	70	
19.	Арга хэмжээ 5.4. Тайлан мэдээний батлагдсан хуваарийн дагуу хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичиг болон өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, бусад мэдээ, судалгааг нэгтгэн тайлгаха;	60	10	70	70	
Дундаж оноо:				61,5	61,5	

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
				1
1.	Арга хэмжээ 2.1. Салбарын холбогдох хууль эрх зүй, дүрэм, журмыг судлах, судалгааны баримт материалтай танилцах;	100%	15	15
2.	Арга хэмжээ 2.2. Мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр зохих сургалтад хамрагдах, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох;	100%	15	15
Дундаж оноо			15	15

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
			1
1.	Хандлага, ёс зүй	6	6
2.	Дун шинжилгээ хийх	6	6
3.	Асуудал шийдвэрлэх	6	6
4.	Хариуцлагатай байдал	5	5

5.	Ажлын цаг ашиглалт	5	5
	Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		

Дундаж оноо

5,6

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

5,6

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)	
		1	2
1.	Хандлага, ёс зүй		2
2.	Багаар ажиллах		8
3.	Харилцаа		8
	Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлтт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	61,5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	5,6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
	Нийт оноо =	90,1

Үнэлгээ өгсөн:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга

Нэгжийн дарга

(С.Рэгзэн)

2025.06.13 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:  
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн

Төрийн жинхэнэ албан хаагч:

(Б.Янжмаа)

2025.06.13 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Төрийн захиргаа удирдлагын газрын дарга

(В.Түвшинжаргал)

2025.06.20 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Яамны хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч

(Б.Баянжаргал)

2025.06.20 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Төсвийн шууд захирагч

(Н.Мөнхзүйл)

2025.06.20 (огноо)

